

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/141/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/177  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Х.ЭНХТУЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2021-01/177-01/177  
19020543

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>82,770,850.03</b>	<b>89,536,116.86</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	82,770,850.03	89,536,116.86
354	<b>Хангамжийн материал</b>	80,743,028.12	85,981,683.02
35410	Бичиг хэргийн материал	45,000.00	825,790.00
35420	Аж ахуйн материал	45,111,730.50	46,187,331.95
35430	Сэлбэг хэрэгсэл	32,503,277.62	36,346,591.07
35440	Түлш, шатах тослох материал	2,329,919.00	2,249,919.00
35460	Хүнсний материал	753,101.00	372,051.00
35600	Мал амьтад	2,027,821.91	3,554,433.84
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>963,158,741.93</b>	<b>912,112,410.92</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	963,158,741.93	912,112,410.92
392	<b>Биет хөрөнгө</b>	923,438,741.93	872,392,410.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	945,414,246.25	945,414,246.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-152,676,965.72	-206,545,195.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,918,800.00	17,918,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,902,133.32	-5,352,133.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,701,557.93	202,010,718.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-140,663,770.12	-148,874,228.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,707,203.88	138,385,717.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-91,793,242.37	-87,383,148.88
39217	Ном	15,733,045.40	16,817,635.40
393	<b>Биет бус хөрөнгө</b>	39,720,000.00	39,720,000.00
39301	Программ хангамж	1,010,000.00	1,010,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,010,000.00	-1,010,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39,720,000.00	39,720,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,045,929,591.96</b>	<b>1,001,648,527.78</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,576,374.96</b>	<b>11,570,894.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,576,374.96	11,570,894.00
413	<b>Өглөг</b>	1,576,374.96	11,570,894.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	68,249.36	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,508,125.60	11,570,894.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,044,353,217.00</b>	<b>990,077,633.78</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,044,353,217.00	990,077,633.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	536,197,162.35	536,197,162.35
51101	Өмч: - төрийн	536,197,162.35	536,197,162.35
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-267,667,029.43	-321,942,612.65
51210	Өмнөх үеийн үр дүн	-267,667,029.43	-267,667,029.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-54,275,583.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	775,823,084.08	775,823,084.08
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,045,929,591.96</b>	<b>1,001,648,527.78</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,417,434,687.96</b>	<b>1,391,426,296.05</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,379,377,887.96</b>	<b>1,359,879,296.05</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	30,142,887.96	55,921,396.05	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,142,886.95	37,217,259.02	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	521,200.00	143,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,621,686.95	37,074,259.02	
120009	Бусад орлого	01.01	18,704,137.03	
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	125,727,600.00	157,464,800.00	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,223,507,400.00	1,146,493,100.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,223,507,400.00	1,146,493,100.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>38,056,800.00</b>	<b>31,547,000.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	38,056,800.00	31,547,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,056,800.00	31,547,000.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,478,966,229.06</b>	<b>1,445,701,879.27</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,478,966,229.06</b>	<b>1,445,701,879.27</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,260,033,022.87	1,339,667,513.18	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	878,057,533.99	929,276,759.38	
210101	Үндсэн цалин	609,574,281.54	628,420,696.60	
210102	Нэмэгдэл	169,743,228.40	205,418,167.42	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,462,371.00	30,571,126.53	
210104	Урамшуулал	78,277,653.05	64,866,768.83	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,341,240.18	122,452,735.88	
210201	Тэтгэврийн даатгал	78,480,151.38	85,693,315.72	
210202	Тэтгэмжийн даатгал	5,833,765.48	9,199,576.85	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,667,112.26	7,359,768.81	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,163,523.29	1,836,529.71	
210205	Эрүүл мэндийн даатгал	13,196,687.77	18,363,544.79	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,639,557.00	140,761,517.72	
210301	Гэрэл, цахилгаан	8,552,500.00	8,372,519.32	
210302	Түлш, халаалт	111,972,057.00	130,813,998.40	
210303	Цэвэр, бохир ус	2,115,000.00	1,575,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,415,965.00	1,832,197.00	
210401	Бичиг хэрэг	1,047,100.00	-254,793.00	
210402	Тээвэр, шатахуун	893,291.00	904,990.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.00	637,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	183,550.00	112,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,572,024.00	432,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46,275,919.00	55,392,746.09	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,000.00	600,000.00	

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	43,032,619.00	46,990,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,225,300.00	7,802,596.09
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,591,800.00</b>	<b>4,089,800.00</b>
210604	Урсгал засвар	1,591,800.00	4,089,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>176,000.00</b>	<b>28,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	176,000.00	28,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,156,000.00</b>	<b>00.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,156,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>101,379,007.70</b>	<b>85,833,757.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,640.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,858,363.00	1,290,250.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,200,004.70	84,543,506.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>218,933,206.19</b>	<b>106,034,366.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,481,800.00</b>	<b>68,397,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,396,300.00	18,657,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,660,500.00	48,744,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,425,000.00	995,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>179,451,406.19</b>	<b>37,637,266.09</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-61,531,541.10</u></b>	<b><u>-54,275,583.22</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-61,531,541.10</u></b>	<b><u>-54,275,583.22</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	536,197,162.35	775,823,084.08	-206,135,488.32	1,105,884,758.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>536,197,162.35</b>	<b>775,823,084.08</b>	<b>-206,135,488.32</b>	1,105,884,758.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-61,531,541.10	-61,531,541.10
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>536,197,162.35</b>	<b>775,823,084.08</b>	<b>-267,667,029.43</b>	1,044,353,217.00
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>536,197,162.35</b>	<b>775,823,084.08</b>	<b>-267,667,029.43</b>	1,044,353,217.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>536,197,162.35</b>	<b>775,823,084.08</b>	<b>-267,667,029.43</b>	1,044,353,217.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-54,275,583.22	-54,275,583.22
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>536,197,162.35</b>	<b>775,823,084.08</b>	<b>-321,942,612.65</b>	990,077,633.78

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,389,165,250.00</b>	<b>1,354,352,037.03</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,351,108,450.00</b>	<b>1,322,805,037.03</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,873,450.00	18,847,137.03	
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	521,200.00	143,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	521,200.00	143,000.00	
120009	Бусад орлого	1,352,250.00	18,704,137.03	
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	125,727,600.00	157,464,800.00	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,223,507,400.00	1,146,493,100.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,223,507,400.00	1,146,493,100.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>38,056,800.00</b>	<b>31,547,000.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	38,056,800.00	31,547,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,056,800.00	31,547,000.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,389,165,250.00</b>	<b>1,354,352,037.03</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,389,165,250.00</b>	<b>1,354,352,037.03</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,150,524,143.81</b>	<b>1,220,513,170.94</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	878,057,532.99	929,351,905.86	
210101	Үндсэн цалин	609,574,280.54	628,376,437.03	
210102	Нэмэгдэл	169,743,228.40	205,378,700.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,462,371.00	30,730,000.00	
210104	Урамшуулал	78,277,653.05	64,866,768.83	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,272,990.82	122,333,338.76	
210201	Тэтгэврийн даатгал	78,411,902.02	85,629,865.03	
210202	Тэтгэмжийн даатгал	5,833,765.48	9,185,337.94	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,667,112.26	7,348,110.36	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,163,523.29	1,833,856.86	
210205	Эрүүл мэндийн даатгал	13,196,687.77	18,336,168.57	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	124,727,600.00	130,663,749.32	
210301	Гэрэл, цахилгаан	9,408,400.00	8,337,519.32	
210302	Түлш, халаалт	113,204,200.00	120,751,230.00	
210303	Цэвэр, бохир ус	2,115,000.00	1,575,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,930,040.00	4,622,587.00	
210401	Бичиг хэрэг	320,000.00	449,997.00	
210402	Тээвэр, шатахуун	464,000.00	558,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.00	750,000.00	
210404	Ном, хэвлэл	484,340.00	484,590.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,761,700.00	2,200,000.00	

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,969,680.00	22,909,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,000.00	600,000.00
210502	Хоол, хүнс	23,169,680.00	19,309,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,640,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	2,364,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,364,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	176,000.00	164,490.00
210702	Дотоод албан томилолт	176,000.00	164,490.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,774,900.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,774,900.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,615,400.00	8,104,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,400.00	1,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,420,000.00	6,404,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>238,641,106.19</b>	<b>133,838,866.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,189,700.00	96,201,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,647,900.00	27,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,396,300.00	18,657,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,660,500.00	48,744,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,485,000.00	1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	179,451,406.19	37,637,266.09
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,262,570,800.0	1,248,923,536.9	13,647,263.1	98.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,262,570,800.0	1,248,923,536.9	13,647,263.1	98.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,230,933,200.0	1,220,123,536.9	10,809,663.1	99.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	929,319,500.0	929,305,268.8	14,231.2	100.0
210101	Үндсэн цалин	628,329,800.0	628,329,800.0	-	100.0
210102	Нэмэгдэл	205,378,700.0	205,378,700.0	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,096,000.0	30,730,000.0	(634,000.0)	102.1
210104	Урамшуулал	65,515,000.0	64,866,768.8	648,231.2	99.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,458,100.0	122,333,338.8	3,124,761.2	97.5
210201	Тэтгэврийн даатгал	88,285,400.0	85,629,865.0	2,655,535.0	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,293,200.0	9,185,337.9	107,862.1	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,434,500.0	7,348,110.4	86,389.6	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,858,700.0	1,833,856.9	24,843.1	98.7
210205	Эрүүл мэндийн даатгал	18,586,300.0	18,336,168.6	250,131.4	98.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	131,053,800.0	130,663,749.3	390,050.7	99.7
210301	Гэрэл, цахилгаан	8,408,400.0	8,337,519.3	70,880.7	99.2
210302	Түлш, халаалт	120,751,400.0	120,751,230.0	170.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,894,000.0	1,575,000.0	319,000.0	83.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,565,000.0	4,422,590.0	142,410.0	96.9
210401	Бичиг хэрэг	450,000.0	450,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	558,000.0	(58,000.0)	111.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.0	750,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	485,000.0	484,590.0	410.0	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.0	180,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.0	2,000,000.0	200,000.0	90.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,988,800.0	22,909,100.0	7,079,700.0	76.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.0	600,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	26,388,800.0	19,309,100.0	7,079,700.0	73.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.0	3,000,000.0	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,221,000.0	2,221,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	2,221,000.0	2,221,000.0	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	223,000.0	164,490.0	58,510.0	73.8
210702	Дотоод албан томилолт	223,000.0	164,490.0	58,510.0	73.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,104,000.0	8,104,000.0	-	100.0

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.0	1,700,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,404,000.0	6,404,000.0	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,637,600.0</b>	<b>28,800,000.0</b>	<b>2,837,600.0</b>	<b>91.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,637,600.0</b>	<b>28,800,000.0</b>	<b>2,837,600.0</b>	<b>91.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,137,600.0	27,300,000.0	2,837,600.0	90.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,500,000.0	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,262,570,800.0</b>	<b>1,262,570,800.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,129,296,000.0</b>	<b>1,129,296,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,129,296,000.0	1,129,296,000.0	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>133,274,800.0</b>	<b>133,274,800.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	133,274,800.0	133,274,800.0	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>76.0</b>	<b>72.0</b>	<b>4.0</b>	<b>94.7</b>
620001	Удирдах ажилтан	1.0	4.0	(3.0)	400.0
620002	Гүйцэтгэх ажилтан	54.0	43.0	11.0	79.6
620003	Үйлчлэх ажилтан	21.0	25.0	(4.0)	119.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>67,544,597.00</b>	<b>67,544,597.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>67,544,597.00</b>	<b>67,544,597.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>143,000.00</b>	<b>143,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>143,000.00</b>	<b>143,000.00</b>
210604	Урсгал засвар	143,000.00	143,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,401,600.00</b>	<b>67,401,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,401,600.00</b>	<b>67,401,600.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,657,500.00	18,657,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	48,744,100.00	48,744,100.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>67,544,597.00</b>	<b>67,544,597.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>67,544,597.00</b>	<b>67,544,597.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,544,597.00	67,544,597.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>	<b>-</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн эрүүл, аюулгүй, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн хүмүүжил, хөгжил, төлөвшил, сурлагын чанар ахиц гаргахыг эрхэм зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Захирлын 2021 он 4 дүгээр сарын 01-ний өдрийн Б/14 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 онд 16 ажил гүйцэтгэхээр төлөвлөн, дотоод хяналтыг хэрэгжүүлэн, улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 1,262,570.8 мянга төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,938.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,203.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 1,262,570.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 67,544.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 1,343,901.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 23,388.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,024.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,084.6 мянган төгрөгийн ном, нийт 33,497.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,450.9 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 23,046.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 14,008.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 60,720.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 67,963.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэлгүй, 11,570.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь халаалтын өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 89,536.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 912,112.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	82,770.9	89,536.1	6,765.3
Үндсэн хөрөнгө	963,158.7	912,112.4	(51,046.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,045,929.6</b>	<b>1,001,648.5</b>	<b>(44,281.1)</b>
Өр төлбөр	1,576.4	11,570.9	9,994.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,044,353.2	990,077.6	(54,275.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,045,929.6</b>	<b>1,001,648.5</b>	<b>(44,281.1)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 89,536.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 6,765.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 912,112.4 мянган төгрөг болж 51,046.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 990,077.6 мянган төгрөг болж 54,275.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,670,368.1 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,670,368.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан. Төсвийн тодотголоор батлагдсан төсвийг 407,797.3 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар бууруулан 1,262,570.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 1,262,570.8 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,248,923.5 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 13,647.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,248,923.5 мянган төгрөг буюу 98.9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 67,544.6 мянган төгрөг төвлөрч, урсгал шилжүүлэгт 67,401.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 143.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгө дансанд 23,388.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,024.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,084.6 мянган төгрөгийн ном, нийт 33,497.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,450.9 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 23,046.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрийн дагуу 25,424.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 109 нэр төрлийн 122,916.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3 нэр төрлийн 510.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 3,044.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн төлөвтэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 57,480.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 178,763.4 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 29,816.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 22,021.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 454.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 126,471.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 29,816.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулав. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулган шалгахад нийт үр дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Санхүүгийн тайланд түлш халаалтын өглөг 3,145.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцооллыг шалгахад 17 нэр төрлийн 12,941.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглагдах жилийг алдаатай тохируулж, хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид тооцоогүй нь: УСНББОУС 17-той нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Бараа материалын бүртгэлийг шалгахад 24 нэр төрлийн 2,027.8 мянган төгрөгийн хангамжийн материал /сургалтын хэрэглэгдэхүүн/-ыг Мал амьтад дансанд бүртгэж тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5. НДШ төлөлтийн 2021 оны 12 дугаар сарын тайланд 130.2 мянган төгрөгийн дутуу төлөлттэй тайлагнасныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Ану Сервис ХХК-тай тооцоо нийлсэн актаар 11,571.0 мянган төгрөгийн өр төлбөртэй гэж баталгаажуулсныг санхүүгийн тайланд тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 454.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд сахилгын шийтгэлтэй албан хаагчид нийт 454.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-д "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэлтэй албан хаагчид олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 22,021.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 10,450.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн дээд шатны байгууллагын баталсан шийдвэрийг мөрдөн ажиллаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацааны эцэст түлш халаалтын 11,570.9 мянган төгрөгийн өглөг үүссэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийг даруй барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 109 нэр төрлийн 122,916.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх

##### **2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 3,044.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

##### **3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **3.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 510.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль	11	178,763.4	5	29,816.6	1	454.0	2	22,021.8	3	126,471.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)